



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 12 сарын 10 өдөр

Дугаар СХШ-2025/28

Сүхбаатар сум

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Ойн анги
ОНӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд
хийсэн хяналт шалгалтын дүн

**НЭГ: ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО, ХАМАРСАН ХҮРЭЭ, ХУГАЦАА,
ШАЛГУУЛСАН БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

1.1 Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан 2025 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн СХШ-2025/01/ОНА дугаартай "Санхүүгийн хяналтын ажлын удирдамж"-аар санхүү төсвийн гүйцэтгэл болон Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг хянан шалгах, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгөх засаж залруулан зөвлөх зорилготойгоор хяналт шалгалт хийлээ.

1.2 Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын СХШУАБ Т.Мөнхзул ахлан, дотоод аудитор Д.Ванчигмаа 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрөөс ажлын 20 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

1.3 Шалгалтаар Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Ойн анги ОНӨААТҮГ-ын 2024 он, 2025 оны 3-р улирлын санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны баримт материал, тайлан тооцоог хамруулав.

1.4. Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Ойн анги ОНӨААТҮГ-ын улсын бүртгэлийн 8165785 дугаар регистртэй, Төрийн Банк дах үндсэн үйл ажиллагааны 151400010441 дугаартай дансныг ашиглаж байна.

1.5 Тус газрын Төсвийн орлого зарлага, тайлагналт, Төрийн банкны харилцах дансанд 1-р гарын үсгийг Сэлэнгэ аймаг Хүдэр сумын ойн анги ОНӨААТҮГ-ын дарга Т.Мөнхтуул 2-р гарын үсгийг нягтлан бодогч Т.Нямгэрэл нар зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулж байна.

1. Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Засаг даргын 2025 оны 01-р сарын 15 өдрийн А/03 дугаарын захирамжаар бүтэц нь 5 хүний орон тоогоор батлагдаж . дарга 1 ойн ахлах инженер 1 , техникч 1, нягтлан бодогч 1 мод үржүүлгийн ажилтан 1 гэсэн 5 ажиллаж байна

4325001179

"Ойгоос бэлтгэх хэрэглээний болон үйлдвэрлэлийн зориулалттай модыг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээлтийг хуулийн дагуу хийлгэх, модны үр, тарьцыг бэлтгэх, зэрлэг ан амьтныг хамгаалах" гэсэн үндсэн чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын эрхэм зорилго: Ойн аж ахуйн эрхлэх, ойн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах тогтвортой ашиглах нөхөн сэргээх нэгдсэн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх оршино.

Хүдэр сумын Ойн анги нь ОНӨААТҮГ нь нийт 205561 га газартай бүсээр ангилбал хамгаалалтын бүсийн хязгаарлалтын бүс 12706 га ,ногоон бүс 13833га , хориотой зурвасын ойн 12915га ,ашиглалтын бүсийн ойн 84319 га газрууд хамаарагдаж байна.Ойн анги нь 10 ойн нөхөрлөл ,31 аж ахуйн нэгж байгууллагуудтай ойн санг гэрээгээр эзэмшүүлж ойжуулалт,нөхөн сэргээлт,мод үржүүлэг, талбай тусгаарлах ойн ашиглалтыг , ойн менежмент төлөвлөгөөний биелэлтийг дүгнэн ажилласан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлиг, 2013 оны "Засгийн газарт чиглэл өгөх тухай" 178 дугаар зарлиг, аймаг, сумын Засаг даргын захирамжийн хүрээнд Бүх нийтээр мод тарих өдрийг зохион байгуулах, сумын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цэцэрлэгжүүлэх, нийтийн эзэмшлийн талбайг тохижуулах ажлыг зохион байгуулж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлиг, 2013 оны "Засгийн газарт чиглэл өгөх тухай" 178 дугаар зарлиг, аймаг, сумын Засаг даргын захирамжийн хүрээнд Бүх нийтээр мод тарих өдрийг зохион байгуулах, сумын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цэцэрлэгжүүлэх, нийтийн эзэмшлийн талбайг тохижуулах ажлыг зохион байгуулан сумын хэмжээнд нийт 5,600.0 төгрөгийн санхүүжилтээр 62 өрх 1250 мод, 31 аж ахуйн нэгж 150 мод бут тарьж, нийт 1400 ширхэг мод бутыг тарьж, ургуулан усалгаа, арчилааг хийж мод тарьж, арчилж хамгаалах чиглэлээр 200 ширхэг гарын авлага бэлтгэн тарааж ажилласан байна.

ХОЁР. ШАЛГАЛТАД ХАМРАГДАХ АСУУДЛУУД

2.1 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэрлэлтийн талаар

Хүдэр сумын Ойн анги ОНӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад санхүүгийн хууль тогтоомжийн хүрээнд УСНББОУС, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг санхүү, бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулж байна

2.2. Батлагдсан төсөв, гүйцэтгэл зориулалтын дагуу зарцуулсан байдал

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/02 дугаар захирамжаар тус байгууллагын 2024 оны үйлдвэрлэл,

санхүүгийн төлөвлөгөөг буюу нийт орлого, зарлагыг тус бүр 280,968.9 мянган төгрөгөөр баталсан байна

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл хүснэгт 1 харуулбал :

Хүснэгт 1 (мянган төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны		хэтрэлт хэмнэлт	Биелэлт хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Нийт орлого	м/төг	280,986.9	115,622.3	(165,364.6)	41.2
2	Үүнээс:Цэвэр борлуулалт	м/төг	269,900.0	224,860.1	(161,675.5)	40.9
3	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	м/төг	11,068.9	7,397.8	(3,671.1)	66.8
4	Нийт зардал	м/төг	280,986.9	239,691.7	41,295.2	85.3
5	Борлуулсан барааны өртөг	м/төг	230,008.5	202,645.7	27,362.8	88.1
6	Ерөнхий ба удирдлагын зардал	м/төг	34,478.4	34,478	-	
7	Борлуулалт, маркетингийн зардал	м/төг	16,500.0	2,568	13,931.9	15.6
8	Татварын дараах ашиг (алдагдал)	м/төг		(165,364.6)		

2024 оны тайлант хугацаанд үндсэн үйл ажиллагааны орлого батлагдсан төлөвлөгөөнөөс 165,364.6 мянган төгрөгөөр буюу 58.8 хувиар тасарч, гүйцэтгэлээр нийт 115,622.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн нь 41.2 хувийн биелэлттэй байна. Төвлөрүүлсэн нийт орлогыг үйл ажиллагааны чиглэлээр нь ангилж үзвэл: Талбай тусгаарлалтын орлого: 57,457.0 мянган төгрөг, Тарьц суулгацын орлого: 50,767.5 мянган төгрөг, Туслах үйл ажиллагааны орлого: 7,397.8 мянган төгрөгийг тус тус бүрдүүлжээ. Орлого тасрах гол шалтгаан нь 1,200 га талбайд тусгаарлалт хийх төлөвлөгөөг 206 га талбайгаар дутуу гүйцэтгэсэн байсантай шууд холбоотой. 2024 оны тайлант хугацаанд нийт зардлыг 280,986.9 мянган төгрөгөөр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 239,691.7 мянган төгрөг зарцуулж, төлөвлөгөөний биелэлт 85.3 хувьтай буюу 41,295.2 мянган төгрөгийн зардлын хэмнэлт үүссэн байна, Гэвч энэхүү зардлын бууралт нь үйл ажиллагааны үр ашиг, үндсэн үйл ажиллагаа болох талбайд тусгаарлалт, мод үржүүлэг, ойжуулалтын ажил төлөвлөгөөт хэмжээнд хүрээгүйгээс үүдэлтэй зардлын дутуу зарцуулсан байна.

2024 оны борлуулалтын орлогын тасалдал нь төлөвлөлтийг бодит нөөц боломжтой уялдуулаагүйгээс үүдэлтэй байна

2024 оны гүйцэтгэлийн үр дүн нь байгууллагын санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл үүсгэгч байна. Цаашид үйл ажиллагааны төлөвлөлтийг боловсруулахдаа зөвхөн тоон үзүүлэлтэд тулгуурлах бус, бодит нөөц боломж болох техник хэрэгслийн хүчин чадал, ажиллах хүчний нөөц болон гадаад хүчин зүйлийн нөлөөллийг нарийвчлан тооцох шаардлагатай байна.

2024 оны санхүүгийн байдлын тайлан

хүснэгт 2 харуулбал :

Хүснэгт 2

мянган төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл		Өөрчлөлт
		01-р сарын 01	12-р сарын 31	
1	ХӨРӨНГӨ			3=2-1
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	151,220.9	27,151.5	(124,069.4)
1.1.2	Дансны авлага	1,013.6	817.8	(195.8)
1.1.6	Бараа материал	29,985.4	39,673.8	9,688.4
1.2.1	Үндсэн хөрөнгө	71,039.6	79,633.2	8,593.6
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	253,259.6	147,276.3	(105,983.3)
2.1	Өр төлбөр		457.9	457.9
2.3.8	Эздийн өмч	23,900.9	78,804.9	54,904.9
2.3.9	Хуримтлагдсан ашиг	229,358.7	59,933.5	(169,425.1)
2.3.10	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		8,080.0	8,080.0
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	253,259.6	147,276.3	(105,983.30)

Хүдэр сумын Ойн анги ОНӨААТҮГ-ын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлан нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 105,983.1 мянган төгрөгөөр буюу 41.8 хувиар буурсан байна. Энэ нь мөнгөн хөрөнгө 124,069.4 мянган төгрөгөөр буурч голчлон шалтгаалсан нь Нийт орлого 165,364.6 мянган төгрөг буюу 58.8 хувиар тасарч, үйл ажиллагаа алдагдалтай ажилласны улмаас дутагдсан эх үүсвэрийг оны эхний мөнгөн хөрөнгийн нөөцөөс нөхсөн байна.

2024 оны санхүүгийн тайлангийн гүйцэтгэлээр байгууллагын хуримтлагдсан ашиг оны эхнээс 169,425.1 мянган төгрөгөөр буюу 73.8 хувиар буурсан үзүүлэлттэй нь байгууллагын санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна

2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Засаг даргын 2025 оны 01-р сарын 15 өдрийн А/03 дугаарын захирамжаар Хүдэр сумын Ойн анги орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2025 оны үйл ажиллагааны орлого 274,807.2 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны нийт зардлыг 247,655.2 мянган төгрөгөөр төлөвлөж батлагдсан байна.

2025 оны 3-р улирлын байдлаараа Үндсэн үйл ажиллагааны орлого нийт 179,634.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Борлуулалтын орлогыг үйл ажиллагааны чиглэлээр нь ангилж үзвэл: Талбай тусгаарлалтын орлого: 119,051.9 мянган төгрөг, Тарьц суулгацын орлого: 60,581.8 мянган төгрөг, Туслах үйл ажиллагааны орлого: 105.3 мянган төгрөгийг тус тус бүрдүүлсэн бөгөөд төлөвлөөгөөс хэмнэлт 95,068.2 мянган төгрөгөөр буюу 65.4 хувьтай байна. Нийт зардал гүйцэтгэлээр 176,621.7 мянган

төгрөг зарцуулж, төлөвлөгөөнөөс 71,034.8 мянган төгрөгийн буюу 71.3 хувьтай зардлын хэмнэлт байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл хүснэгт 3 харуулбал :

Хүснэгт 3

мянган төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 оны		хэтрэлт хэмнэлт	Биелэлт хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Нийт орлого	м/төг	274,807.2	179,739.0	95,068.2	65.4
2	Үүнээс:Цэвэр борлуулалт	м/төг	252,639.4	179,634.0	73,005.4	71.1
3	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	м/төг	22,167.8	105.0	22,062.8	0.3
4	Нийт зардал	м/төг	247,655.8	176,621.0	71,034.8	71.3
5	Борлуулсан барааны өртөг	м/төг	223,655.8	153,421	70,234.8	68.5
6	Ерөнхий ба удирдлагын зардал	м/төг	24,000.0	23,200	800.0	96.6
7	Борлуулалт, маркетингийн зардал	м/төг				
8	Татварын дараах ашиг (алдагдал)	м/төг	27,151	3,118.0	24,033	11.4

2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн байдлын тайлан

хүснэгт 4 харуулбал

Хүснэгт 4

мянган төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл		Өөрчлөлт
		01-р сарын 01	09-р сарын 30	
1	ХӨРӨНГӨ			3=2-1
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	27,151.5	18,517.8	(8,633.7)
1.1.2	Дансны авлага	817.8	10.0	807.0
	Татвар, НДШ – ийн авлага		287	287.0
1.1.3	Бусад авлага		1,800.0	1,800.0
1.1.6	Бараа материал	39,673.8	60,006.5	20,332.7
1.2.1	Үндсэн хөрөнгө	79,633.2	69,321.6	(10,311.6)
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	147,276.3	149,942.9	2,666.6
2.1	Өр төлбөр	457.9	47.2	-(410.7)
2.3.8	Эздийн өмч	78,804.9	78,804.9	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	59,933.5	63,010.8	3,077.3
2.3.10	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,080.0	8,080.0	-
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	147,276.3	149,942.9	2,666.6

Хүдэр сумын Ойн анги ОНӨААТҮГ-ын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,666.6 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар өссөн байна. Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 18,517.8 мянган төгрөг болж 8,633.7 мянган төгрөгөөр буурсан. Дансны авлага 10.0 мянган

төгрөгөөр, татвар НДШ-ийн авлага 287.0 мянган төгрөгөөр, бусад авлага 1,800.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, бараа материалын 20,332.7 мянган төгрөгөөр өссөн, үндсэн хөрөнгө 10,311.6 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар буурсан, өр төлбөр 410.7 мянган төгрөгөөр буурсан, хуримтлагдсан ашиг 3,077.3 мянган төгрөгөөр нэмэгдснээс нийт хөрөнгийн дүн өссөн байна.

2.3.1 Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт олголтын байдал цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал:

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Засаг даргын 2025 оны 01-р сарын 15 өдрийн А/03 дугаарын захирамжаар Хүдэр Ойн анги орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын албан хаагчдын бүтэц орон тоог 5 батлагдсан байна.

2024 оны цалингийн зардал 132,803.5 мянган төгрөгөөр зарцуулсан буюу 5 орон тоогоор ажилласан байна. 2025 оны 3-р улирлын байдлаараа цалингийн зардал 85,374.9 мянган төгрөгөөр зарцуулсан буюу 5 орон тоогоор ажилласан байна.

2024-2025 оны 3-р дугаар улирлын байдлаараа цалин хөлсний тогтоолт, тооцоололтыг тулган баталгаажуулахад зөрүүгүй байна.

2.4.2 өрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

2024, 2025 оны 3 улирлын байдлаар төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар хийгдэх өндөр дүнтэй худалдан авалт бараа, ажил, бараа үйлчилгээ хийдээгүй байна

2.4.3 Авлага, өр төлбөрийг баталгаажуулж , данс бүртгэлд бүрэн тусгасан эсэх

Авлагын үлдэгдлийн талаар: 2025 оны 3-р улирлын гүйцэтгэлээр нийт 2,097.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Үүнээс үндсэн үйл ажиллагааны дансны авлага 10.0 мянган төгрөг, төрөөс авах татвар, НДШ-ийн авлага 287.0 мянган төгрөг байгаа бол үлдсэн 1,800.0 мянган төгрөгийг бусад авлага байна. Бүх үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулсан.

2.4.4 Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал

Хүдэр сумын Ойн анги ОНӨААТҮГ-ын 2024 санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой 1 зөвлөмж авч хэрэгжүүлэн ажилласан байна.

2.4.5 Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт

Үндсэн хөрөнгө:

Үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг явцад ашиглалтын хугацаа дууссан, цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийн жагсаалт гаргаж өмч хамгаалах зөвлөлд шилжүүлэн , акталж устгах, шилжүүлэх зэргээр холбогдох дээд газрын шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж , данс бүртгэлд тусгасан байна

2024, он 2025 оны 3 улирлын байдлаар өмч хамгаалах байнгын зөвлөл нь үндсэн хөрөнгө шинээр авч байгаа хөрөнгөд бүрэн бүтэн байдал чанарын шаардлага хангаж байгаа тал дээр хяналт тавин 4 удаа хуралдсан байна.

2.4.6 Гүйцэтгэх удирдлагын дотоод хяналт тогтолцоо төлөвшсөн эсэх.

Хүдэр ойн анги ОНӨААТҮГ Газар нь Сумын Засаг даргын захирамжийн дагуу Байгаль орчныг хамгаалах багц хууль, Ойн тухай хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан журам, стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор мод бэлтгэлийн явцын хяналт болон хуурайшилтын хугацаанд хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ой хээрийг түймрээс хамгаалах зорилгоор Байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, Экологийн асуудал хариуцсан байцаагчтай хамтран хяналт шалгалтыг 21 удаа зохион байгуулж илэрсэн зөрчлийг газар дээр нь арилгах, мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтанд өгч ажилласан байна.

2.4.7 Санхүүгийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлийг заавар аргачлалын дагуу бүрэн үнэн зөв хөтөлсөн эсэх

Хүдэр ойн анги ОНӨААТҮГ-ын 2024,2025 оны 3-р улирлын байдлаарх санхүүгийн ажил гүйлгээг анхан шатны баримтаар баталгаажуулсан эсэхийг тулган баталгаажуулахад 2024 онд худалдан авалтын цахим төлбөрийн баримтын бараа ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээг бөөн дүнгээр бүртгэсэн нийт 17,827.0 мянган төгрөгийн худалдан авалтын анхан шатны баримтын шаардлага хангаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх " Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно.", 13.6 дахь "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна."Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "Анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5 дахь " Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2.4.8 Төсөвт төвлөрүүлэх орлогын үндэслэлтэй төлөвлөж бүрэн төвлөрүүлсэн эсэх

Хүдэр сумын Ойн анги ОНӨААТҮГ нь 2024 онд Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 273,610.9 мянган төгрөгийн төлөвлөгөө батлагдсанаас орлогыг 232,257.9 мянган төгрөгийг буюу 95 хувьтай төсөвт төвлөрүүлсэн байна. 2025оны

3-р дугаар улирлын байдлаараа Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 273,605.9 мянган төгрөгийн төлөвлөгөө батлагдсанаас орлогыг 220,752.4 мянган төгрөгийн буюу 80.6 хувьтай төсөвт төвлөрүүлсэн байна.

2.4.9 Аймгийн ИТХ-аар баталсан 2024, 2025 онд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай хэрэглээний мод ,түлээ бэлтгэх хуваарийг батлах тухай тогтоолын хэрэгжилт

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12-р дугаар сарын 25 өдрийн 144-р дүгээр тогтоолын , Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12-р дугаар сарын 27 өдрийн 28-р дүгээр тогтоолын хэрэгжилтийг 2024-2025 онд ойгоос бэлтгэх үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай хэрэглээний мод ,түлээний мод хуваарь батлагдсан дагуу тухай "Ойгоос мод бэлтгэх үйл ажиллагааг" зохион байгуулан ажиллаж байна

Хүснэгт 5

мянган төгрөгөөр

Үзүүлэлт	2024 он			2025 он		
	Батлагдсан хуваарь	Бэлтгэсэн модны хэмжээ /м3/	Үлдэгдэл модны хэмжээ /м3/	Батлагдсан хуваарь	Бэлтгэсэн модны хэмжээ /м3/	Үлдэгдэл модны хэмжээ /м3/
ААН	12,134	10,992	1,142	11068	10348	720
	5,032	4,481	551	3,591	3,389	202
Нөхөрлөл	64	64	-	130	130	0
	60	60	-	100	100	0
иргэн	346	308	38	800	560	240
	5,747	3,108	2,639	6644	2560	4084
нийт	23,383	19,013	4,370	22,333	17,087	5,246

2024 онд ойгоос бэлтгэх үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай хэрэглээний мод,түлээний бэлтгэх хуваарийн хэрэгжилт 81,4 хувьтай гүйцэтгэсэн байна. 2025 оны 3-р улирлын байдлаараа бэлтгэх үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай хэрэглээний мод,түлээний бэлтгэх хуваарийн хэрэгжилт 76,5 хувьтай ажиллаж байна.

Гурав. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал

2024 оны эцэс, 2025 оны 3-р улирлын төсөв, санхүүгийн болон үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл хөтлөлт, анхан шатны баримтын бүрдүүлэлт зэргийг тулган шалгахад холбогдох хууль, журам, стандартын дагуу хөтлөн явуулж байгаа боловч тэдгээртэй холбоотой хуулийн тогтоомж зөрчих үйлдэл оршсоор байна. Үүнд:

Илрүүлэлт 1. 2024 онд худалдан авалтын цахим төлбөрийн баримтын бараа ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээг бөөн дүнгээр бүртгэсэн нийт 17,827.0 мянган төгрөгийн худалдан авалтын анхан шатны баримтын шаардлага хангаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх " Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно.", 13.6 дахь "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна."Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "Анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар"-ын 6.5 дахь " Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана." гэсэн заалтуудыг зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалт хийх тухай бүрд бараа ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо ширхгээр орлого авч, цахим баримтаар баталгаажуулж, зарцуулалтаараа зарлагадаж байх албан шаардлага хүргүүлэв.

Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:

4.1 Дүгнэлт:

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан удирдамжаар Хүдэр сумын ойн анги ОНӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр "Дунд" эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

4.2 Шийдвэрлэлт:

Хүдэр сумын Ойн анги ОНӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар нийт 17,827.0 мянган төгрөгийн 1 зөрчил илэрснээс санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн зөрчлийг таслан зогсоох 17,827.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, хүргүүлэхээр шийдвэрлэв.

Тав. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:

Шалгалтын явцад тус байгууллагын дарга, нягтлан бодогч, шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий холбогдох албан хаагчтай уулзаж асуулга, тодруулга авч Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулсан болно. Шалгалтаар илэрсэн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй

зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг тус Хүдэр сумын ойн анги ОНӨААТҮГ-ын дарга, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа. Санхүүгийн хяналт шалгалтын тэмдэглэлд тусгагдсан зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийн тайлан, нотлох баримтын хамт 2025 оны 12 дугаар сарын 31-ны дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт албан бичгээр ирүүлэхийг дарга, нягтлан бодогч нарт нь хариуцуулав.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН ДОТООД АУДИТОР
DM
Д.ВАНЧИГМАА

ТАЙЛАН ХЯНАСАН
СХШАБ *Мөнхзул* Т.МӨНХЗУЛ



ТАНИЛЦСАН:

ХҮДЭР УМЫН ОЙН АНГИ ОНӨААТҮГ
ДАРГА *Т.Мөнхтуул* Т.МӨНХТУУЛ

НЯГТЛАН БОДОГЧ
Т.Нямгэрэл Т.НЯМГЭРЭЛ